

Салбарын хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын
хяналтын улсын ахлах байцаагч Нороврэнцэнгийн Одончимэгийн
2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан

НЭГ. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхлэх дуусах хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрэх түвшин(биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчин, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.							
1.	Арга хэмжээ 1.1. ТХШТХ-ийн.9.1.2. Хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын 6 хуудсыг шинэчлэн батлуулна.	Батлагдсан хяналтын хуудас	ЭМС-ын 2024 оны А/76 тушаалаар батлуулсан 15 хяналтын хуудас	Батлагдсан хяналтын хуудас -6	Батлагдсан хяналтын хуудасны тоо-6. Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын 6 (10.11.3, 10.11.5, 10.11.8, 10.11.9, 10.12.1, 10.13.1 кодтой)хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулан хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.	2025.01 2025.02	100%
2.	Арга хэмжээ 1.2. ТХШТХ-ийн 9.2.1 Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэл шинээр эрхлэх, Нялх, балчир хүүхдийн хүнсний үйлдвэрлэл шинээр эрхлэх, Агуулахын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас шинээр боловсруулж батлуулна.	Батлагдсан шинэ хяналтын хуудас	ЭМС-ын 2024 оны А/76 тушаал, ЭМС, ХХААХҮС-ын А/261/А190 дугаартай хамтарсан тушаалаар батлуулсан 3 хяналтын хуудас	Батлагдсан шинэ хяналтын хуудас-3	Шинээр батлуулсан хяналтын хуудасны тоо-3 10.11.1 кодтой “Нялх, балчир хүүхдийн хүнсний үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”, 10.11.14 кодтой “Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэл шинээр эрхлэх үйл ажиллагаанд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас”, 10.13.3 кодтой “Хүнсний агуулахын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас” шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулан хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.	2025.01 2025.02	100%

Зорилт 2. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

3.	Арга хэмжээ 2.1. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоол, ЭМС-ын 2024 оны А/496 дугаар тушаал Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 527 газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулгыг III улиралд нэгтгэнэ. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/496 дүгээр тушаалын хавсралтад заасан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 527 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарласнаас 330 объект хамрагдаж, хамралт 62.6% байна. Төлөвлөгөөт шалгалтаар хамрагдсан объектуудын эрсдэлийг 9 хяналтын хуудасны дагуу үнэлэхэд 13.9% (46) нь их, 48.4% (160) нь дунд, 37.5% (124) нь бага эрсдэлтэй үнэлэгдээд байна. Хяналт шалгалтын явцад хяналтын хуудасны асуумжаар шаардлага хангаагүй 3358 зөрчил, дутагдал илрүүлэн, 1237 буюу 36.8%-г газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 2383 заалттай 208 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 24 аж ахуйн нэгж, иргэнд 66,500,000(жаран зургаан сая таван зуун мянга)төгрөгийн шийтгэвэр ногдуулж, 34,700,000(гучин дөрвөн сая долоон зуун) төгрөг буюу 52.1%-г) барагдуулсан, хугацаа болоогүй 31,800,000 төгрөгийн шийтгэвэр хүлээгдэж байна. Зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 58 заалттай 19 эрх бүхий албан тушаалтны албан даалгавраар үүрэг өгч, тайлант хугацаанд хэрэгжилт 72.4% байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.	2025.01 2025.11	Хугацаа болоогүй
	Дэд арга хэмжээ 2.1.1. Төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	“Хүнсний чиглэлийн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамж боловсруулан газрын даргаар батлуулж, 2025.02 05-ны өдрийн 10-00/13 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлсэн.	2025.01 2025.02	100% ✓
	Дэд арга хэмжээ 2.1.2.	Үндсэн арга хэмжээний	-	40%	Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Увс, Өвөрхангай аймгийн 14 объектод	2025.04 2025.05	100% ✓

Увс, Өвөрхангай аймгийн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн 14 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.	гүйцэтгэлд эзлэх хувь			төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарласнаас 12(85.7%) объект хамрагдаж, Увс аймагт 1 ААН үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж барилгын материалын худалдаа эрхлэх болсон, Өвөрхангай аймгийн 1 ААН улирлын чанартай сүүний үйлдвэрлэл явуулдаг(6-9 сар) тул шалгалт хийх хугацаа хойшилсон. Хяналт шалгалтаар объектуудын эрсдэлийг 6 хяналтын хуудасны дагуу үнэлэхэд 16.6% (2) нь их, 66.6% (8) нь дунд, 16.6 % (2) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, эрсдэлийн дундаж 39.5%, хууль, тогтоомжийн хэрэгжилтийн дундаж 60.7 % байна. Шалгалтаар нийт 76 зөрчил, дутагдал илэрч, 3 ААН-д 6,500,000(зургаан сая таван зуун мянган) төгрөгийн шийтгэлийг харьяалалын дагуу аймгийн Эрүүл мэндийн газар хялбаршуулсан журмаар ногдуулж, 9 аж ахуйн нэгжид “Дутагдал арилгуулах тухай” 91 заалттай албан шаардлагыг хугацаатай хүргүүлж, 5 албан шаардлагын хэрэгжилт ирсэн байна. Хяналт шалгалтын дүнг шалгалтын бүрэлдэхүүнийг ахалсан улсын байцаагчид тухай бүрд хүргүүлж, газрын даргад нэгдсэн танилцуулга танилцуулагдсан. Увс аймгийн хяналт шалгалтын дүнг 2025.04.30-ны өдөр Удирдлагын Зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэр гаргуулсан.		
Дэд арга хэмжээ 2.1.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	50%	Улсын хэмжээний хяналт шалгалтын дүнгийн танилцуулга нэгтгэх хугацаа болоогүй.	2025.09 2025.10	Хугацаа болоогүй.

	саналын хамт газрын удирдлагад танилцуулна. Арга хэмжээ 2.2. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, улирлын чанартай ажил, үйлчилгээ, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна. /Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадам, Шинэ жил, бусад/	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	2024-2025 оны шинэ жил, 2025 оны цагаан сарын баяр угтсан хяналт шалгалтын дүнгийн танилцуулгыг нэгтгэн, газрын даргад танилцуулж, ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газарт 9/1436 дугаартай албан бичгээр болон цахим хаягаар тус тус хүргүүлсэн. Эх үрсийн баярын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан, аймаг, нийслэлийн ЭМГ-аас шалгалтын дүнгийн танилцуулгыг хүлээн авч нэгтгэж байна. Тус хяналтыг ЭМЯ-ны СХГ ахлах тул ХХААХҮЯ-ны СХГ-ын хяналт шалгалтын дүнг авч нэгтгэн газрын даргад танилцуулагдана.	2025.02 2025.09	100%
4.	Дэд арга хэмжээ 2.2.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, улирлын чанартай ажил, үйлчилгээ, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчаар 2025.01.29-ний өдөр хамтарсан удирдамжийг батлуулан, 08-00-02/07 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлж, хяналт шалгалтуудыг тухай бүрд чиглүүлэн зохион байгуулан ажиллаж байна.	2025.01 2025.02	100%
	Дэд арга хэмжээ 2.2.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	50%	ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын ерөнхий байцаагч нарын хамтарсан удирдамжийн хүрээнд 2024-2025 оны шинэ жил, 2025 оны цагаан сарын баяр угтан гүйцэтгэсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар давхардсан тоогоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 3237 объектод хяналт шалгалт хийж, 2455 зөрчил дутагдлыг илрүүлж, 39 ААН, иргэнд 240 заалттай улсын байцаагчийн зөвлөмж, 51 ААН, иргэнд дутагдлыг арилгуулахаар 296 заалттай албан шаардлагыг хүргүүлж, 175 заалт буюу 59.1%-ийг хангуулж, Зөрчлийн тухай	2025.03 2025.10	100%

					хуулийн тусгай ангийг зөрчсөн 40 аж ахуй нэгж, иргэнд 34,200,000 (гучин дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийн шийтгэврийг хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн ногдуулж, 100 хувь барагдуулан, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 29 заалттай 18 албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Шошгын зөрчилтэй 354 ширхэг, 18 кг, 2,378,000 (хоёр сая гурван зуун далан найм) төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгэж, хадгалалтын хугацаа хэтэрсэн 3022 ширхэг, 68 кг, 7,057,000 (долоон сая тавин долоон мянган) төгрөгийн бүтээгдэхүүнийг албадлагын журмаар хураан авч, холбогдох орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.		
5.	Арга хэмжээ 2.3. Нялх, балчир хүүхдийн хүнс импортлогч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулгыг III улиралд нэгтгэнэ. - Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/17 дугаартай удирдамжийн хүрээнд 19(55.8%) объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтад хамрагдсан объектыг 10.13.3 кодтой “Хүнсний агуулахын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах” хяналтын хуудсаар үнэлэхэд 12 (63%) нь дунд, 7 (37%) бага эрсдэлтэй үнэлэгдэн, 70 зөрчил, дутагдал илрүүлэн, 4 ААН-д 6 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Хяналт үргэлжилж байна.	2025.01 2025.10	
	Дэд арга хэмжээ 2.3.1. Нялх, балчир хүүхдийн хүнс	Үндсэн арга хэмжээний	-	10%	Нялх, балчир хүүхдийн хүнс импортлогч аж ахуйн үйл ажиллагаанд урьдчилан	2025.01 2025.02	100%

	импортлогч аж ахуйн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж батлуулна.	гүйцэтгэлд эзлэх хувь			сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж 2025.02.12-ны өдөр батлуулна, 10-00/17 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн хяналт шалгалтыг эхлүүлээд байна.		
	Дэд арга хэмжээ 2.3.3. Салбарын хяналтын газар, НЭМГ-ын хамтарсан хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	40%	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулгыг III улиралд нэгтгэнэ.	2025.10	Хугацаа болоогүй.
Зорилт 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
	Арга хэмжээ 3.1. Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3 Барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргана.	Хүсэлтийн шийдвэрлэлт	100%	100%	Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр шинээр барих болон өргөтгөх барилга байгууламжийн зурагт эрүүл ахуйн хяналт хийлгэх 105 хүсэлтийг хүлээн авч, эрүүл ахуйн хяналт хийснээс 98 зураг төсөлд улсын (ахлах) байцаагчийн дүгнэлт гаргаж баталгаажуулсан байна. Зураг төсөл, баримт бичгийн бүрдэл дутуу 7 ажлын зургийг үндэслэл бүхий албан бичгээр буцаасан. Ажлын зураг төслийг зөвшилцөхгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн 4 ААН, 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 10,250,000(арван сая хоёр зуун тавин мянган)төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар ногдуулан ажиллалаа. Хяналт шалгалт үргэлжилж байна.	2025.01 2025.11	100%
6.		Нэгдсэн танилцуулгад чиглэлийн хяналт шалгалтын дүнгийн нэгтгэлийг хүргүүлнэ.		Нэгдсэн танилцуулгад чиглэлийн хяналт шалгалтын дүнгийн нэгтгэлийг хүргүүлнэ.			
7.	Арга хэмжээ 3.2. Эрүүл ахуйн тухай хуулийн 8.2 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны	Хүсэлтийн шийдвэрлэлт	100%	100%	Эхний хагас жилийн тайлант хугацаанд ААН дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй байна.	2025.01 2025.11	

	гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход эрүүл ахуйн дүгнэлт гаргана.						
8.	Арга хэмжээ 3.3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт Өндөр эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах хяналт шалгалтыг хамтран зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ. Эхний хагас жилд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт -100% Аж ахуйн нэгж, иргэнээс өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд дүгнэлт гаргуулах 23 (нийслэлд 14, аймагт 9) хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дотор 100% шийдвэрлэсэн. Хяналт шалгалтаар үйлдвэрийн эрүүл ахуйн бүсийн хэмжээ хангаагүй 2 ААН-ийн хүсэлтийг буцааж, 21 үйлдвэрийг 10.11.1 кодтой “Нялх, балчир хүүхдийн хүнс үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”, 10.11.2 кодтой “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийх эрүүл ахуйн хяналтын хуудас”, 10.11.15 кодтой “Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-аар үнэлхэд 4 (19%) нь “их эрсдэлтэй”, 8 (38%) “дунд эрсдэлтэй”, 9 (42.8%) нь “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн. Бага эрсдэлтэй үнэлэгдсэн 9(сүү боловсруулах- 1, мах боловсруулах-7, балчир хүүхдийн хүнс үйлдвэрлэгч-1) ААН, иргэнд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор баталсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”, Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011-ийн эрүүл ахуйн шаардлагыг	2025.01 2025.11	

					хангаж байгаа тухай улсын байцаагчийн 9 дүгнэлт үйлдэж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтын биелэлтийг хангуулж ажиллалаа. Хяналт шалгалт үргэлжилж байна.		
	Дэд арга хэмжээ 3.3.1. Өндөр эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчаар 2025.02.25-ны өдөр хамтарсан удирдамжийг батлуулан, 08-00-02/10 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалт хийгдэж байна.	2025.01 2025.02	100% 100 ✓
	Дэд арга хэмжээ 3.3.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	90%	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ.	2025.10 2025.11	Хугацаа болоогүй.
9.	Арга хэмжээ 3.4. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 23 дугаар зүйл Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн хоол хүнсний аюулгүй байдалд төлөвлөгөөт бус хөндлөнгийн хяналт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ. Эхний хагас жилд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт -100%. Төрийн тусгай хамгаалалтын газраас ирүүлсэн 25 албан бичгийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх заалтын хүрээнд хөтөлбөрт тусгагдсан нэр бүхий 78 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, ирүүлсэн албан хүсэлтийг 100% шийдвэрлэж ажиллалаа. Хяналт шалгалтаар эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаагүй 54 дутагдал илрүүлж, арилгуулах арга хэмжээг яаралтай авсаны дүнд болзошгүй эрсдэлээс сэргийлэн, хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангуулан ажиллалаа.	2025.01 2025.11	100%
	Дэд арга хэмжээ 3.4.1.	Үндсэн арга хэмжээний	-	10%	ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчаар 2025.02.25-ны өдөр	2025.01	

	Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн хоол хүнсний аюулгүй байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж боловсруулж батлуулна.	гүйцэтгэлд эзлэх хувь			хамтарсан удирдамжийг батлуулан, 08-00-02/10 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалт хийгдэж байна.	2025.02	100%
	Дэд арга хэмжээ 3.4.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	90%	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ.	2025.10 2025.11	Хугацаа болоогүй.
10.	Арга хэмжээ 3.5. Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.10.3, 7.11.3 Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаархи болон тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж дүгнэлт гаргана.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ. Эхний хагас жилд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт -100%. Эхний хагас жилийн байдлаар батлагдсан удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн ЭМГ-аас тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах үйл ажиллагааны зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацааг сунгуулах 572 худалдааны газарт хяналт хийж, 10.13.2 кодтой хяналтын хуудасны үнэлгээгээр “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн 547 газарт “Ажлын байрны тухай” улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Хяналт шалгалтаар “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2024” стандарт хангаагүй давхардсан тоогоор 1074 зөрчил, дутагдлыг илрүүлэн, 49.3%-г богино хугацаанд арилгуулан, 73 заалттай 15 улсын байцаагчийн зөвлөмж, 171 заалттай 17 хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Шалгалтаар 2	2025.01 2025.11	100%

					ААН, иргэнд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн заалтаар 1,300,000 (нэг сая гурван зуун мянга)төгрөгөөр торгох шийтгэлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлээд байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.		
	Дэд арга хэмжээ 3.5.1. Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах эрүүл ахуйн нөхцөлд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах тухай удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	Хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж 2025.01.09-ний өдөр батлуулан, 10-00/03 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн хяналт шалгалтыг эхлүүлээд байна.	2025.01 2025.02	100%
	Арга хэмжээ 3.5.2. Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн эрүүл мэндийн дүгнэлт гаргуулах хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Эхний хагас жилд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт -100%. Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодисын агууламж, чанар, аюулгүй байдалд дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлсэн давхардсан тоогоор 14 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 15 нэр төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнд Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журамд заасны дагуу дагалдах бичиг баримтад эрсдэлийн үнэлгээ хийж, бүтээгдэхүүний Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид шинжлүүлэн, дүнг үндэслэн стандартын шаардлагад нийцсэн тухай улсын ахлах байцаагчийн 8 дүгнэлт үйлдэж, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэн, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.6, 6.7 дахь заалтуудын хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. Хяналт шалгалтын явцад янжуур тамхины загвар дээжийн хайрцаг дээрхи эрүүл мэндийн анхааруулга, шошгын мэдээлэлд илэрсэн дутагдлыг арилгуулахаар 3 ААН-д 10 заалттай албан шаардлагыг хүргүүлэн, хэрэгжилтийг 100% хангуулаад байна.	2025.01 2025.11	100%

	Дэд арга хэмжээ 3.5.3. Хуулийн этгээдийн хүсэлтээр тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаархи болон тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнгийн танилцуулгыг нэгтгэнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ. Хугацаа болоогүй.	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ.	2025.10 2025.11	Хугацаа болоогүй.
	Арга хэмжээ 3.6. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15¹.1.3, 15².1.3 Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах хяналт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга гарсан байна. Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга гарсан байна.	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ. Эхний хагас жилд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт -100%. Эхний хагас жилийн байдлаар ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн хамтран баталсан удирдамжийн хүрээнд ААН-ээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 1168 объектод төлөвлөгөөт бус хамтарсан хяналт шалгалт хийлээ. 8.10.4 кодтой “Согтууруулах ундаагаар үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг шалгах хяналтын хуудас”, 8.11.2 кодтой “Согтууруулах ундаа худалдах худалдааны газрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ны үнэлгээгээр “бага эрсдэлтэй” үнэлгээтэй 996 ААН-д холбогдох стандартыг хангасан тухай улсын(ахлах) байцаагчийн дүгнэлт гарган ажиллалаа. Хяналт шалгалтын явцад хяналтын хуудасны асуумжаар шаардлага хангаагүй 1125 дутагдал илрүүлэн, 37 аж ахуйн нэгжид 276 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж, 61.2%-г арилгуулсан	2025.01 2025.11	
11.							

					байна. Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналтын нэгжээс Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийг үндэслэн 2 аж ахуйн нэгжид нийт 4,000,000(дөрвөн сая) төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар ногдуулж, 75%-г барагдуулаад (хугацаа болоогүй 25%)байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.		
	Дэд арга хэмжээ 3.6.1. Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хамтарсан хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчаар 2025.01.07-ны өдөр хамтарсан удирдамжийг батлуулан, 08-00-02/02 дугаартай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, хяналт шалгалт хийгдэж байна.	2025.01 2025.02	100%
	Дэд арга хэмжээ 3.6.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	90%	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулгыг IV улиралд нэгтгэнэ.	2025.10 2025.11	Хугацаа болоогүй.
12.	Арга хэмжээ 3.9. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 ² .1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ.	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	Эхний хагас жилийн байдлаар аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 60 албан бичиг хүлээн авсанаас 33 нь хариугүй, 37 хариутай бичгийн 34-г буюу 91.89 хувийг хугацаанд нь шийдвэрлэсэн, 3 албан бичиг шийдвэрлэх шатандаа, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй.	2025.01 2025.11	100% <i>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5².1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ.</i>

Зорилт 4. Орон нутаг дахь улсын /ахлах/ байцаагчдыг бодлого, удирдлага, мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангах

1.	ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаалын 6 дугаар хавсралтын 2.1.1 Сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн орон нутаг дахь хүнсний асуудал хариуцсан улсын байцаагчдыг чадавхижуулах давтан сургалтыг зохион байгуулна.	Сургалтын тайлан	-	Сургалт зохион байгуулж тайлан гаргасан байна.	III улиралд төлөвлөсөн.	2025.09 2025.10	Хугацаа болоогүй.
----	---	------------------	---	--	-------------------------	--------------------	-------------------

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрэх түвшин(биелэлт)	Эхлэх дуусах хугацаа	Биелэлтийн хувь
1.	Стандартчилалын хорооны техникийн хорооны бүрэлдэхүүнд ажиллах.				Засгийн газрын 2025.02.05-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Сүү бэлтгэл, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг шинэчлэх ажлын хэсэгт ажиллаж, батлуулсан. 2026.01.01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.	2025.01	100%
2.	Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний баг				ХАБҮЛЛ-ийн захирлын тушаалаар эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж, 2 ААН-ийн шинээр бүртгүүлэх хүнсний баяжуулсан 4 нэмэлтийн эрсдэлийн үнэлгээ хийж дүгнэлт, санал өгч ажилласан.	2025.02 2025.05	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин(биелэлт)		Эхлэх дуусах хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд

1.	Хувь хүний хөгжлийн чиглэлээр сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	2025.03.10-ны өдөр Монголын Залуу эрдэмтдийн холбооноос зохион байгуулсан “Хувь хүний хөгжил-ээрэг хандлага” сэдэвт сургалтад хамрагдаж, өдрийн гэрчилгээ авсан.	2025.02 2025.03	
----	---	--	--	--	--	--------------------	--

2.	Мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	2024 онд 2 удаагийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	2025 оны 7 сарын 04-ний өдрөөс 4 хоног НҮБ-ээс зохион байгуулах Хүнсний аюулгүй байдлын эрсдэлд үнэлгээ хийх, эрэмбэлэх үндэсний сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн.	2025.04 2025.11	Хугацаа болоогүй
----	--	--	--	--	--	--------------------	------------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Н.ОДОНЧИМЭГ

2025.06.10